



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/229

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3 1. Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Дамдин овогтой Мэндбаярын эзэмшлийн Хэрлэн сумын 4 дүгээр баг /Сариг/. Пунцаг гудамжид байрлах, үйлчилгээний зориулалттай 1000 м² газрыг иргэн Алтангэрэл овогтой Дунгар-Өлзийд 57 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн А.Дунгар-Өлзийн эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн А.Дунгар-Өлзийд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны А/605 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА